

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/156-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3047 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Албан шаардлага:.....	19
5.2 Зөвлөмж .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СОЁЛ,  
УРЛАГ, АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН ДАРГА  
С.БААСАНЖАРГАЛ ТАНАА

2025.02.25 № 120-2025/156/11А-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-аар тайлант оны 4 сараас эхлэн орон нутгийн нэмэгдэл авсан зэргээс шалтгаалж тус газрын 2024 оны цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 89 хувиар нэмэгдсэн бөгөөд урсгал зардлын 57.1 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байна.

### Аудитын гол асуудал

Төлбөр тооцоог гарахаас нь өмнө урьдчилан хянан баталгаажуулаагүй нь санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, төсөв хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах эрсдэлтэй байна.

432502159

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” тогтоолоор харьяалагдах яам нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон өөрчлөгдөж, бүтэц, бүрэлдэхүүн, эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбогдуулан “Соёл, урлагийн газар” гэснийг “Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар” гэж өөрчлөн зохион байгуулсан байна.

Тус газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>42,888,141.70</u></b>	<b><u>35,564,963.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>5,587.00</b>	<b>5,587.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>5,587.00</b>	<b>5,587.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>5,587.00</b>	<b>5,587.00</b>
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	5,587.00	5,587.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>28,684,678.70</b>	<b>-</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	194,678.70	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	28,490,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>14,197,876.00</b>	<b>35,559,376.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>14,197,876.00</b>	<b>35,559,376.00</b>
35410	Бичиг хэргийн материал	954,700.00	1,193,200.00
35420	Аж ахуйн материал	7,036,000.00	12,603,900.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,302,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,207,176.00	20,460,276.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>103,996,004.79</u></b>	<b><u>988,934,433.39</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>103,996,004.79</u></b>	<b><u>988,934,433.39</u></b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b><u>102,796,004.79</u></b>	<b><u>988,034,433.39</u></b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	733,973,961.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	67,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(4,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,500,500.00	70,531,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,232,262.00)	(20,752,312.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,841,301.00	117,410,601.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,653,121.71)	(12,184,654.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,838,500.00	42,838,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,498,912.50)	(6,782,762.50)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>1,200,000.00</u></b>	<b><u>900,000.00</u></b>
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(600,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>146,884,146.49</u></b>	<b><u>1,024,499,396.39</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>28,490,000.00</u></b>	<b><u>1,429,510.23</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>28,490,000.00</u></b>	<b><u>1,429,510.23</u></b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b><u>28,490,000.00</u></b>	<b><u>1,429,510.23</u></b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	109,378.16
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>1,320,132.07</u></b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	1,320,132.07
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>118,394,146.49</u></b>	<b><u>1,023,069,886.16</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>118,394,146.49</u></b>	<b><u>1,023,069,886.16</u></b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b><u>118,394,146.49</u></b>	<b><u>1,021,330,186.16</u></b>
51210	Өмнөх үеийн үр дүн	55,674,282.49	116,654,446.49

51220	Тайлант үеийн үр дүн	62,719,864.00	904,675,739.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	1,739,700.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>146,884,146.49</b>	<b>1,024,499,396.39</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>383,423,800.00</b>	<b>1,512,439,813.37</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>69,481,400.00</b>	<b>821,731,140.97</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>69,481,400.00</b>	<b>821,731,140.97</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	69,481,400.00	818,831,240.97
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	2,899,900.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>313,942,400.00</b>	<b>690,708,672.40</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>262,652,400.00</b>	<b>457,888,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	262,652,400.00	457,888,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>51,290,000.00</b>	<b>232,820,172.40</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,210,000.00	74,570,172.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,080,000.00	158,250,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>320,703,936.00</b>	<b>567,801,073.70</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>320,703,936.00</b>	<b>567,801,073.70</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>262,985,855.07</b>	<b>509,442,108.85</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>136,756,499.87</b>	<b>259,141,800.35</b>
210101	Үндсэн цалин	83,749,738.79	153,992,924.83
210102	Нэмэгдэл	27,231,398.68	64,126,675.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,553,000.00	20,928,000.00
210104	Урамшуулал	3,222,362.40	20,094,200.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,039,393.44</b>	<b>31,838,164.94</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,637,268.37	21,553,000.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,369,264.38	2,566,569.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,095,411.56	1,467,539.72
210204	Ажилгүйдлийн даатгал	264,351.49	1,239,973.41
210205	Эрүүл мэндийн даатгал	2,673,097.64	5,011,081.61
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,902,400.00</b>	<b>49,339,499.19</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,210,287.77	1,659,474.19
210302	Түлш, халаалт	36,751,128.43	44,633,925.00
210303	Цэвэр, бохир ус	1,940,983.80	3,046,100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,950,906.00</b>	<b>16,643,160.00</b>
210401	Бичиг хэрэг	1,104,450.00	4,803,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,330,200.00	4,243,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	884,356.00	1,571,460.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	185,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,631,900.00	5,840,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>508,270.00</b>	<b>7,874,850.00</b>
210502	Хоол, хүнс	508,270.00	7,874,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>26,488,462.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	26,488,462.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,877,000.00</b>	<b>85,849,060.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,877,000.00	85,849,060.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,951,385.76</b>	<b>32,267,112.37</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,850,902.00	2,790,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,484,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,100,483.76	25,992,312.37
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,718,080.93</b>	<b>58,358,964.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.00</b>	<b>10,260,700.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,140,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	2,120,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>57,418,080.93</b>	<b>4,367,638.00</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,367,638.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>43,730,626.85</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	43,730,626.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>62,719,864.00</b>	<b>944,638,739.67</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>39,963,000.00</b>
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	39,963,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	<b>(39,963,000.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>62,719,864.00</b>	<b>904,675,739.67</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>313,942,400.00</b>	<b>719,198,672.40</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>313,942,400.00</b>	<b>719,198,672.40</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>262,652,400.00</b>	<b>457,888,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	262,652,400.00	457,888,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>51,290,000.00</b>	<b>261,310,172.40</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,210,000.00	88,780,172.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,080,000.00	172,530,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>313,977,402.00</b>	<b>587,136,172.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>313,977,402.00</b>	<b>587,136,172.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>227,769,321.07</b>	<b>527,897,207.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>137,285,770.03</b>	<b>257,241,974.58</b>
210101	Үндсэн цалин	85,231,055.08	152,228,722.84
210102	Нэмэгдэл	26,705,855.57	64,399,454.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,239,621.92	20,928,000.00
210104	Урамшуулал	3,109,237.46	19,685,797.14
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,162,013.04</b>	<b>32,113,801.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,621,400.71	21,815,840.55
210202	Тэтгэмжийн даатгал	1,529,057.40	2,566,569.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,099,672.70	1,467,539.72
210204	Ажилгүйдлийн даатгал	264,351.48	1,252,770.41
210205	Эрүүл мэндийн даатгал	2,647,530.75	5,011,081.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,902,400.00</b>	<b>49,339,499.19</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,210,287.77	1,659,474.19
210302	Түлш, халаалт	36,751,128.43	44,633,925.00
210303	Цэвэр, бохир ус	1,940,983.80	3,046,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,187,966.00</b>	<b>22,777,410.00</b>
210401	Бичиг хэрэг	1,879,660.00	3,351,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,295,200.00	5,545,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	884,356.00	1,616,560.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,000.00	185,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,088,750.00	12,079,650.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>4,853,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,853,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>26,488,462.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	26,488,462.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>25,327,000.00</b>	<b>104,559,650.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,327,000.00	104,559,650.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,904,172.00</b>	<b>30,523,310.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,904,172.00	26,158,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,364,350.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>86,208,080.93</b>	<b>59,238,964.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.00</b>	<b>11,140,700.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,140,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	3,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>85,908,080.93</b>	<b>4,367,638.00</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	28,490,000.00	4,367,638.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>43,730,626.85</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	43,730,626.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(35,002.00)</b>	<b>132,062,500.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>132,062,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>132,062,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>132,062,500.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	39,963,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	92,099,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(132,062,500.00)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,589.00	5,587.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,587.00	5,587.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	55,674,282.49	55,674,282.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	55,674,282.49	55,674,282.49
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	62,719,864.00	62,719,864.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	118,394,146.49	118,394,146.49
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	118,394,146.49	118,394,146.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,739,700.00	-1,739,700.00

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	116,654,446.49	116,654,446.49
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	1,739,700.00	0.00	1,739,700.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	904,675,739.67	904,675,739.67
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	1,739,700.00	1,021,330,186.16	1,023,069,886.16

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>457,888,522.00</b>	<b>414,157,873.15</b>	<b>43,730,648.85</b>	<b>90.45</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>457,888,522.00</b>	<b>414,157,873.15</b>	<b>43,730,648.85</b>	<b>90.45</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>446,747,800.00</b>	<b>403,017,173.15</b>	<b>43,730,626.85</b>	<b>90.21</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>258,562,100.00</b>	<b>233,774,201.18</b>	<b>24,787,898.82</b>	<b>90.41</b>
210101	Үндсэн цалин	152,368,700.00	152,228,722.84	139,977.16	99.91
210102	Нэмэгдэл	59,898,200.00	40,931,681.20	18,966,518.80	68.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,419,100.00	20,928,000.00	491,100.00	97.71
210104	Урамшуулал	24,876,100.00	19,685,797.14	5,190,302.86	79.14
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,320,200.00</b>	<b>28,761,262.78</b>	<b>3,558,937.22</b>	<b>88.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,977,800.00	19,536,113.55	2,441,686.45	88.89
210202	Тэтгэмжийн даатгал	2,585,600.00	2,298,366.49	287,233.51	88.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,292,800.00	1,252,977.72	39,822.28	96.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,292,800.00	1,199,129.41	93,670.59	92.75
210205	Эрүүл мэндийн даатгал	5,171,200.00	4,474,675.61	696,524.39	86.53
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>51,514,300.00</b>	<b>49,339,499.19</b>	<b>2,174,800.81</b>	<b>95.78</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,179,600.00	1,659,474.19	(479,874.19)	140.68
210302	Түлш, халаалт	48,834,900.00	44,633,925.00	4,200,975.00	91.40
210303	Цэвэр, бохир ус	1,499,800.00	3,046,100.00	(1,546,300.00)	203.10
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,120,000.00</b>	<b>16,899,310.00</b>	<b>220,690.00</b>	<b>98.71</b>
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	3,351,000.00	249,000.00	93.08
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	3,243,200.00	2,756,800.00	54.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	1,616,560.00	783,440.00	67.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	185,000.00	(65,000.00)	154.17
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	8,503,550.00	(3,503,550.00)	170.07
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>40,000,000.00</b>	<b>39,996,600.00</b>	<b>3,400.00</b>	<b>99.99</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,223,000.00	(223,000.00)	101.12
210602	Тавилга	20,000,000.00	19,773,600.00	226,400.00	98.87
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,000,000.00</b>	<b>5,999,200.00</b>	<b>800.00</b>	<b>99.99</b>
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	5,999,200.00	800.00	99.99

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,231,200.00</b>	<b>21,259,650.00</b>	<b>4,971,550.00</b>	<b>81.05</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,731,200.00	21,259,650.00	4,471,550.00	82.62
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	-	500,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,000,000.00</b>	<b>6,987,450.00</b>	<b>8,012,550.00</b>	<b>46.58</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	2,623,100.00	7,376,900.00	26.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	4,364,350.00	635,650.00	87.29
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,140,722.00</b>	<b>11,140,700.00</b>	<b>22.00</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>11,140,722.00</b>	<b>11,140,700.00</b>	<b>22.00</b>	<b>100.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,140,722.00	8,140,700.00	22.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>457,888,500.00</b>	<b>457,888,500.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>457,888,500.00</b>	<b>457,888,500.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	457,888,500.00	457,888,500.00	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>16.00</b>	<b>10.00</b>	<b>6.00</b>	<b>62.50</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	8.00	6.00	57.14
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>261,310,172.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>221,347,172.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>216,979,534.40</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>23,467,773.40</b>
210102	Нэмэгдэл	23,467,773.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,352,539.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,279,727.00
210202	Тэтгэмжийн даатгал	268,203.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	214,562.00
210204	Ажилгүйдлийн даатгал	53,641.00
210205	Эрүүл мэндийн даатгал	536,406.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,878,100.00</b>
210402	Тээвэр, шатахуун	2,302,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,576,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>56,956,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	958,000.00
210602	Тавилга	55,998,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,489,262.00</b>
210702	Дотоод албан томилолт	20,489,262.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>83,300,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,300,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,535,860.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,535,860.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,367,638.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,367,638.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	38,500.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	4,329,138.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>39,963,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	39,963,000.00
222001	Тоног төхөөрөмж	39,963,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>261,310,172.40</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>261,310,172.40</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,780,172.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	172,530,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь "Орон нутгийн түвшинд үндэсний бахархал, эх хэл, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, эх оронч, оюунлаг, бүтээлч монгол хүнийг хөгжүүлнэ." гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёл, урлагийг хөгжүүлэх, иргэний соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Соёлын байгууллагын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу төрөөс санхүүжүүлэх, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авах,
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах,
- Харьяалах нутаг дэвсгэрийн соёлын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих,
- Соёлын статистик мэдээлэл, соёлын байгууллагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 904,675.8 мянган төгрөгөөр буюу 6 дахин өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5.60	5.60	-
Авлага	28,684.70		(28,684.70)
Бараа материал	14,197.80	35,559.40	21,361.60
Үндсэн хөрөнгө	103,996.00	988,934.40	884,938.40
<b>Нийт хөрөнгө</b>	<b>146,884.10</b>	<b>1,024,499.40</b>	<b>877,615.30</b>
Өр төлбөр	28,490.00	1,429.50	(27,060.50)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	118,394.10	1,023,069.90	904,675.80

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	146,884.10	1,024,499.40	877,615.30
---------------------------------------	------------	--------------	------------

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлага данс нь 28,684.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны нэмэлт санхүүжилтийн дансны авлагыг Соёлын яамнаас 14,280.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас 14,210.0 мянган төгрөгийг авч, зориулалтын дагуу зарцуулснаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 35,559.4 мянган төгрөг болж 21,361.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 42,690.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 2,899.9 мянган төгрөгийн камер үнэ төлбөргүй хүлээн авсан болон 24,229.4 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,024,499.4 мянган төгрөг болж 877,615.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 55,998.0 мянган төгрөгийн иж бүрэн тавилгатай, сийлбэртэй гэр, 16,327.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 19,773.6 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан, үнэлгээний компаниар 733,973.9 мянган төгрөгийн барилга үнэлүүлж орлого авсан болон Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 67,500.0 мянган төгрөгийн Фургон автомашин болон 6,120.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Солонгос улсын Жэжү ремакс компаниас 9,843.0 мянган төгрөгийн тоног, төхөөрөмж зэргийг үнэ төлбөргүй хүлээн авснаас тус тус шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 627,286.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 247,703.4 мянган төгрөгөөр бууруулж, 379,578.8 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 169,123.8 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 40,950.7 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 28,700.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 23,050.0 мянган төгрөгөөр бууруулж,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 6,900.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 3,780.9 мянган төгрөгөөр, томилолтын

зардлыг 2,440.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 1,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 78,309.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн төсвийн тодотгол, зохицуулалт хийж / Байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 41,625.0 мянган төгрөгөөр, хангамж, эд хогшил, урсгал засварын зардлыг 40,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 15,731.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг зардлыг 8,140.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 32,187.2 мянган төгрөгөөр бууруулсан байна./ 457,888.5 мянган төгрөгөөр эцэслэсэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 457,888.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 414,157.9 мянган төгрөг буюу 92.4 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлыг 43,730.6 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	431,016.60	391,757.50	39,259.10	92.40
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	11,140.70	11,140.70	0.00	100.00
3	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	15,731.20	11,259.70	4,471.50	71.58
	<b>Дүн</b>	<b>457,888.50</b>	<b>414,157.90</b>	<b>43,730.60</b>	<b>92.40</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130034401 тоот дансанд нийт 261,310.2 мянган төгрөг /бүрэн сийлбэртэй, тавилгатай гэр авахад Соёлын сайдын А/128 дугаар тушаалаар 30,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/182 дугаар тушаалаар 26,000.0 нийт 56,000.0 мянган төгрөг, Соёлын сайдын А/256 дугаар тушаалаар Сайхан сумын соёлын ордонд уран бүтээл хийхэд 42,250.0 мянган төгрөг, Шаамар сумын соёлын төвд лед дэлгэц авахад 40,000.0 мянган төгрөг, А/121 дугаар тушаалаар соёлын бүтээлч сарын аянд 26,000.0 мянган төгрөг, соёлын эрхийн бичгийн санхүүжилтэд 14,280.0 мянган төгрөг, "Нүүдэлчин монгол" соёлын биет бус өвийн их наадамд дээд шатны байгууллагаас

20,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/372 дугаар захирамжаар 32,177,4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 26,820.3 мянган төгрөг, түүх соёлын дурсгалт зүйлийн тооллогод 3,782.5 мянган төгрөг гэх мэт I-ийн санхүүжилт төвлөрч, 256,942.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан үлдэгдэл 4,367.6 мянган төгрөгийг жилийн эцэст төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлантай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 320,703.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,207.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус газар нь мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/* нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд тус төвийн үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган  
төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	682.5	1	682.5	100
Албан шаардлага	2	2,045.3	2	2,045.3	100
Зөвлөмж	1	12,800.0	1	12,800.0	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>15,527.8</b>	<b>4</b>	<b>15,527.8</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар харьяа байгууллагадаа хуваарилах зорилгоор бэлтгэсэн үндсэн хөрөнгийг бараа материалаар бүртгээгүй 39,963.0 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайланд биет бус хөрөнгө худалдан авсныг зардлаар тайлагнасан 92,099.5 мянган төгрөг зэрэг нийт 132,062.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав.

Аудитаар нийт **2,917.3** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 1,320.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 1,597.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

#### 5.1 Албан шаардлага:

1.Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас цэргийн тэтгэвэр тогтоолгосон албан хаагчаас НДШ илүү суутгаж, 1,320.1 мянган төгрөгийн цалингийн өр төлбөр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ, 20.2.5: ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

#### 5.2 Зөвлөмж

##### 1. Нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлагналтай холбоотой асуудал:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.1 Илрүүлэлт: Тайлант оны 5-р сард мэргэжилтэн Б.Хунцэцэгийн 1,597.2 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгал, татварын тайланд тайлагнаагүй байгаа нь нийгмийн даатгал шимтгэл, ХХОАТ-ын авлага, өр төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын болон нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, залруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>3</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Тоо	Дүн	Тоо	Дүн
							Тоо	Дүн				
Харьяа байгууллагадаа хуваарилах зорилгоор бэлтгэсэн үндсэн хөрөнгийг бараа материалгаар бүртгээгүй.	1	39,963.0			1	39,963.0	1	39,963.0				
Мөнгөн гүйлгээний тайланд биет бус хөрөнгө худалдан авсан дүнг зардлаар тайлагнасан.	1	92,099.5			1	92,099.5	1	92,099.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>132,062.5</b>			<b>2</b>	<b>132,062.5</b>	<b>2</b>	<b>132,062.5</b>				

/мянган төгрөгөөр/

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс						Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн						
Төлбөр тооцоог хянаагүйгээс өр төлбөр үүсгэсэн.	1	1,320.1			1	1,320.1						
Нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайланд цалинг дутуу тайлагнасан.	1	1,597.2					1	1,597.2				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,917.3</b>			<b>1</b>	<b>1,320.1</b>	<b>1</b>	<b>1,597.2</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

